

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цогт сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/017/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Алтай хот
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Цэцэгмаа
Утас: 99488754 Цахим хаяг: Tsetsegmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026.03.14

№

144

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цогт сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас түлшний хөнгөлөлтөд 89.3 сая төгрөг, болор цом уралдааны зардалд 1.1 сая төгрөг, бидний нэг өдөр гар бөмбөгийн тэмцээний тамирчдын өмсгөлд 1.0 сая төгрөг, ажил хөдөлмөрөөрөө баг хамт олноо манлайлж аймаг, сумын аварга малчны болзол ханган шалгарсан малчдад хүндэтгэл үзүүлэхэд 22.0 сая төгрөг тус тус зарцуулсан,
- Сумын Засаг даргын Тамгын газарт 45.4 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон,
- Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 15.4 сая төгрөг, шууд бус орлого 6.3 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 0.2 сая төгрөг, газрын төлбөр 1.9 сая , төгрөг, ан амьтны нөөц ашигласны төлбөр 8.7 сая төгрөгөөр тус тус тасарсан,

822511000429

- Тайлант онд төвлөрүүлсэн малын тоо толгойн албан татвараас 3.2 сая төгрөгийг сумын Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлээгүй зэрэг зөрчил нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5, 16 дугаар зүйлийн 16.5.2, 41 дүгээр зүйлийн 41.2.1, 60 дугаар зүйлийн 60.2.8, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 12 дугаар зүйлийн 12.1.4, 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.5, 15.1.8, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1, 7 дугаар зүйлийн 7.1 дахь заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн яамны www.finperform.gov.mn шинэчилсэн системээр нэгтгэсэн байна.

Аудитын гол асуудал

Цогт сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2018-2025 онд хэрэгжиж байгаа болон хэрэгжиж дуусаагүй 389.7 сая төгрөгийн 21 төсөл, арга хэмжээг эрчимжүүлж дуусган хүлээн авах шаардлагатай байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 9 хөтөлбөр, 48 зорилт, 83 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, Цогт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 72.8 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



T. Gynjidmaa Т.ГҮНЖИДМАА

Хоёр.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,307,050.2	1,647,476.9
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	360,976.7	516,318.5
3	1.1.3 АВЛАГА	270,352.9	276,491.2
4	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	400,293.7	418,990.0
5	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	10,697.0	45,921.0
6	1.1.7 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	264,730.0	389,756.3
7	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,830,959.5	2,519,759.4
8	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,830,959.5	2,519,759.4
9	1.2.2.02 Биет хөрөнгө	1,590,585.5	2,279,385.4
10	1.2.2.03 Биет бус хөрөнгө	240,374.0	240,374.0
11	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	3,138,009.7	4,167,236.3
12	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	120,305.4	214,194.3
13	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	120,305.4	214,194.3
14	2.1.1.03 Өглөг	120,305.4	214,194.3
15	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,017,704.3	3,953,042.0
16	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	3,017,704.3	3,953,042.0
17	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	333,028.0	333,028.0
18	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	2,604,484.0	3,539,821.8
19	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	80,192.3	80,192.3
20	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	3,138,009.7	4,167,236.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2,849,773.9	3,347,004.0
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	686,271.5	630,030.6
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар	538,907.4	449,038.6
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	546,252.4	458,379.4
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(7,345.1)	(9,340.8)
6	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	127,643.7	142,437.1
7	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	19,720.5	38,555.0
8	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	125,932.5	2,716,973.4
9	1.1.1.04.3 Тусламжийн орлого	-	1,493,760.6
10	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,037,569.9	-
11	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,327,960.9	2,357,407.1
12	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	2,327,960.9	2,357,407.1
13	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,280,388.4	2,258,207.1
14	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	776,786.4	832,068.0

Цогт сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

15	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,740.4	90,236.6
16	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	542,117.2	703,008.0
17	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	29,584.7	64,674.9
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	43,950.8	5,606.7
19	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	18,538.0	4,670.0
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,102.1	2,175.2
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	748,568.8	555,767.7
22	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,572.6	99,200.0
23	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (Ш)=(1)-(П)	521,812.9	989,596.9
24	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	655,212.6	75,940.0
25	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (УИ)=(1Ү)-(У)	(655,212.6)	(75,940.0)
26	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (Ү1)=(111)+(ҮП)	(133,399.7)	913,656.9

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,134,104.0		3,134,104.0
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	17,000.0		17,000.0
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,151,104.0		3,151,104.0
4	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	(133,399.7)		(133,399.7)
5	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,017,704.3		3,017,704.3
6	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,017,704.3		3,017,704.3
7	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(30.0)		(30.0)
8	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,017,674.3		3,017,674.3
9	1.5 Өмчид гарсан өөрчлөлт	21,710.9		21,710.9
10	1.7 Тайлант үеийн үр дүн	913,656.9		913,656.9
11	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,953,042.0		3,953,042.0

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,808,912.5	2,815,101.2
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	686,271.5	630,030.6
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	538,907.4	449,038.6

Цогт сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-7,345.1	-9,340.8
5	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	127,643.7	142,437.1
6	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	19,720.5	38,555.0
7	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	4,769.5	3,353.8
8	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	14,898.6	16,136.6
9	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	52.4	19,064.6
10	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	85,071.1	2,185,070.5
11	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	85,071.1	147,698.7
12	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,485,360.6
13	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	552,011.2
14	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,037,569.9	0.0
15	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,061,577.8	1,953,069.1
16	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	2,061,577.8	1,953,069.1
17	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,014,005.2	1,853,869.1
18	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	772,537.9	830,523.5
19	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,848.4	110,128.6
20	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	454,027.9	665,869.7
21	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	44,546.3	39,323.5
22	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	45,425.8	10,266.0
23	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	18,538.0	4,670.0
24	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,252.1	2,175.2
25	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	577,828.8	190,912.6
26	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,572.6	99,200.0
27	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (111)=(1)-(11)	747,334.7	862,032.1
28	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	522,764.0	627,690.3
29	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	522,764.0	627,690.3
30	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	522,764.0	627,690.3
31	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (Y1)=(1Y)-(Y)	-522,764.0	-627,690.3
32	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	75,000.0	79,000.0
33	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-75,000.0	-79,000.0
34	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (Y111)=(111)+(Y1)+(Y11)	149,570.7	155,341.8
35	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	211,406.0	360,976.7
36	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	360,976.7	516,318.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,041,131.0	2,793,251.8	247,879.2	91.8
2		Урьд оны үлдэгдлээс санхүүжих	245,270.0	-	245,270.0	-
3	11	Татварын орлого	631,432.5	630,030.6	1,401.9	99.8
4	110	Орлогын албан татвар	466,621.9	449,038.6	17,583.3	96.2
5	1100	Хувь хүний орлогын албан татвар	475,962.7	458,379.4	17,583.3	96.3
6	110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	337,606.2	322,235.9	15,370.3	95.4
7	110002	Үйл ажиллагааны орлого	9,320.7	13,154.0	(3,833.3)	141.1
8	110003	Хөрөнгийн орлого	58,878.7	59,090.2	(211.5)	100.4
9	110008	Шууд бус орлого	70,157.1	63,899.3	6,257.8	91.1
10	1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(9,340.8)	(9,340.8)	0.0	100.0
11	110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(9,340.8)	(9,340.8)	0.0	100.0
12	113	Хөрөнгийн албан татвар	116,544.5	142,437.1	(25,892.6)	122.2
13	113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	3,424.5	4,732.7	(1,308.2)	138.2
14	113002	Бууны албан татвар	3,120.0	3,158.0	(38.0)	101.2
15	113004	Малд ногдуулах албан татвар	110,000.0	134,546.4	(24,546.4)	122.3
16	118	Бусад татвар, төлбөр, хураамж	48,266.1	38,555.0	9,711.2	79.9
17	1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,810.1	3,353.8	(543.7)	119.3
18	118001	Улсын тэмдэгтийн хураамж	2,810.1	2,573.8	236.3	91.6
19	118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	-	780.0	(780.0)	
20	1181	Газрын төлбөр	18,000.0	16,136.6	1,863.4	89.6
21	118101	Газрын төлбөр	18,000.0	16,136.6	1,863.4	89.6
22	1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	27,456.0	19,064.6	8,391.4	69.4
23	118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	27,456.0	18,805.9	8,650.1	68.5
24	118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	-	258.6	(258.6)	
25	12	Татварын бус орлого	2,164,428.5	2,163,221.1	1,207.4	99.9
26	120	Нийтлэг татварын бус орлого	141,631.0	145,999.5	(4,368.5)	103.1
27	120003	Торгуулийн орлого	1,227.0	4,465.0	(3,238.0)	363.9
28	120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	140,404.0	136,641.2	3,762.8	97.3
29	120009	Бусад орлого	-	4,893.3	(4,893.3)	
30	122	Тусламжийн орлого	1,465,210.4	1,465,210.4	-	100.0
31	122003	Аймаг нийслэлээс авсан татаас	1,465,210.4	1,465,210.4	-	100.0

Цогт сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

32	123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	557,587.1	552,011.2	5,575.9	99.0
33	123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	557,587.1	552,011.2	5,575.9	99.0
34	II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,041,131.0	2,636,102.5	405,028.5	86.7
35	21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,062,169.9	1,929,412.2	132,757.7	93.6
36	210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,961,969.9	1,830,212.2	131,757.7	93.3
37	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	836,420.0	830,523.5	5,896.5	99.3
38	210101	Үндсэн цалин	428,000.0	514,594.5	(86,594.5)	120.2
39	210102	Нэмэгдэл	408,420.0	315,929.0	92,491.0	77.4
40	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	143,444.4	110,128.6	33,315.8	76.8
41	210201	Тэтгэврийн даатгал	107,804.4	81,806.9	25,997.5	75.9
42	210202	Тэтгэмжийн даатгал	8,910.0	6,998.7	1,911.3	78.5
43	210203	ҮОМШӨ-ний даатгал	4,455.0	5,283.6	(828.6)	118.6
44	210204	Ажилгүйдлийн даатгал	4,455.0	2,328.3	2,126.7	52.3
45	210205	Эрүүл мэндийн даатгал	17,820.0	13,711.1	4,108.9	76.9
46	2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	676,718.5	665,869.7	10,848.8	98.4
47	210301	Гэрэл, цахилгаан	46,300.0	34,845.3	11,454.7	75.3
48	210302	Түлш, халаалт	622,684.9	598,858.0	23,826.9	96.2
49	210303	Цэвэр, бохир ус	7,733.6	32,166.4	(24,432.8)	415.9
50	2104	Хангамж, бараа материалын зардал	32,040.7	21,875.9	10,164.8	68.3
51	210401	Бичиг хэрэг	5,700.0	2,400.2	3,299.9	42.1
52	210402	Тээвэр, шатахуун	21,650.0	15,877.3	5,772.7	73.3
53	210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,190.7	2,949.5	241.2	92.4
54	210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500.0	649.0	851.0	43.3
55	2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,800.0	10,266.0	10,534.1	49.4
56	210604	Урсгал засвар	20,800.0	10,266.0	10,534.1	49.4
57	2107	Томилолт, зочны зардал	11,600.0	4,670.0	6,930.0	40.3
58	210702	Дотоод албан томилолт	11,600.0	4,670.0	6,930.0	40.3
59	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,300.0	2,175.2	5,124.8	29.8
60	210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,900.0	1,434.6	465.4	75.5
61	210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000.0	-	1,000.0	-
62	210803	Даатгалын үйлчилгээ	500.0	-	500.0	-
63	210804	Тээврийн хэрэгслийн татвар	450.0	260.6	189.4	57.9
64	210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	950.0	480.0	470.0	50.5
65	210807	Газрын төлбөр	2,500.0	-	2,500.0	-
66	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	233,646.3	184,703.3	48,943.0	79.1
67	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	231,646.3	183,743.3	47,903.0	79.3

Цогт сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

68	210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000.0	960.0	1,040.0	48.0
69	213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,200.0	99,200.0	1,000.0	99.0
70	2132	Бусад урсгал шилжүүлэг	100,200.0	99,200.0	1,000.0	99.0
71	213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12,000.0	12,000.0	-	100.0
72	213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	87,200.0	87,200.0	-	100.0
73	213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000.0	-	1,000.0	-
74	22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	899,961.1	627,690.3	272,270.8	69.7
75	223001	Бусад хөрөнгө	899,961.1	627,690.3	272,270.8	69.7
76	23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	79,000.0	79,000.0	-	100.0
77	230001	Эргэж төлөгдөх зээл	79,000.0	79,000.0	-	100.0
78	8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	157,149.3		
79	9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(157,149.3)		
80	7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(157,149.3)		
81	4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	354,475.4		
82	5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	503,224.7		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	40,050.15
2	12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	40,050.15
3	122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	40,050.15
4	1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	40,050.15
5	12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	40,050.15
6	350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,870.15
7	350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,180.00
8	II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,656.90
9	21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	23,656.90
10	210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,656.90
11	2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	17,447.60
12	210402	1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун	17,237.60
13	210403	1.1.1.2.1.1.4.3 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	210.00
14	2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	6,209.30

15	210901	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	6,209.30
----	--------	---	----------

Гурав. Аудитын илрүүлэлт:

3.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Цогт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сан, 4 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар Цогт сумын ЗДТГ-ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн ба сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ХХС, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг аудитын түүвэрт хамруулсан.

3.1 Аудитаар Засаг даргын Тамгын газар, иргэдийн Төлөөлөгчдийн хурлын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар бүртгэл тайлагналтай холбоотой 1,449.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 4 алдааг залруулж, 12.8 сая төгрөгийн 5 зөрчил илрүүлж, 6.4 сая төгрөгийн зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 6.3 сая төгрөгийн 3 зөвлөмж, 1 хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн байна.

3.2 Түүвэрт хамрагдсан Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар санхүүгийн тайлангийн бүртгэл, тайлагналыг 1,027.8 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 8 алдааг залруулж, 17.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 19.1 сая төгрөгийн 3 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

3.3 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 4,399.8 сая төгрөгийн 2 алдаа илрүүлснийг аудитын явцад залруулсан байна. Залруулсан алдаа:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- Өмнөх оны байгууллагад өгөх өглөгийг Сургууль 38.6 сая төгрөг, Цэцэрлэг 14.7 сая төгрөг нийт 53.3 сая төгрөгөөр дутуу тусгасан байсныг залруулсан.

Мэдээллийг орхигдуулсантай холбоотой:

- Засаг даргын Тамгын газар улсын комисс хүлээн авч хөрөнгөд бүртгэх шийдвэр гараагүй 4,346.5 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан байсныг тус тус аудитын хугацаанд залруулсан.

Залруулагдаагүй нийт 194.4 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын төвшнөөс их бөгөөд харьяа байгууллагуудын материаллаг зөрчил 229.9 сая төгрөг байгаа тул шинж чанарыг харгалзан үзэж “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 194.4 сая төгрөгийн 5 зөрчил илрүүлснээс, 3.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 191.2 сая төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлж байна.

3.3.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд бүрдүүлсэн малын тоо толгойн албан татвараас 3.2 сая төгрөгийг сумын Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д "Малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ОНХС-д төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

3.3.2 Албан шаардлага

1. Төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 229.9 сая төгрөгийн зөрчил илэрч 17.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 25.5 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх 4 заалт албан шаардлага, 6.3 сая төгрөгийн 4 заалт зөвлөмж, 180.5 сая төгрөгийн зөрчилд 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлагыг холбогдох байгууллагад хүргүүлсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

3.3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нэг. Төсвийн зохион байгуулалттай холбоотой

1. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 15.4 сая төгрөг, шууд бус орлого 6.3 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 0.2 сая төгрөг, газрын төлбөр 1.9 сая , төгрөг, ан амьтны нөөц ашигласны төлбөр 8.7 сая төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Цогт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 15 дугаар тогтоолыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орлогын төлөвлөгөөг бодитой үндэслэлтэй төлөвлөж гүйцэтгэлийг ханган ажиллах

2. Сумын Засаг даргын Тамгын газарт 45.4 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд

төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Харьяа байгууллагад олгох санхүүжилтийн хуваарийг батлан мөрдөж ажиллах

Хоёр. Арвилан хэмнэлт үр ашигтай холбоотой

1. Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас түлшний хөнгөлөлт 89.3 сая төгрөг, болор цом уралдааны зардалд 1.1 сая төгрөг, бидний нэг өдөр гар бөмбөгийн тэмцээний тамирчдын өмсгөлд 1.0 сая төгрөг, ажил хөдөлмөрөөрөө баг хамт олноо манлайлж аймаг сумын аварга малчны болзол ханган шалгарсан малчдад хүндэтгэл үзүүлэхэд 22.0 сая төгрөг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15 дугаар зүйлийн 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", 15.1.8.-т "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалын хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1-т "Нөөц хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулна", 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг зориулалтын дагуу зарцуулан, хууль тогтоомжоор хориглосон зардалд зарцуулахгүй байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл***(мянган төгрөг)*

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Цогт сумын Засаг дарга	2	4,399,819.6			2	4,399,819.6	2	4,399,819.6	-	-	-	-
Цогт сумын Засаг даргын Тамгын газар	3	1,446,591.2	1	394,970.5	2	1,051,620.7	3	1,446,591.2	-	-	-	-
Цогт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1	3,112.6			1	3,112.6	1	3,112.6	-	-	-	-
Цогт сумын Орон нутгийн хөгжлийн сан	5	967,852.2	1	608,140.3	4	359,711.9	5	967,852.2	-	-	-	-
Цогт сумын Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Цогт сумын Хоршоо хөгжүүлэх сан	3	595,430.6	-	-	3	595,430.6	3	595,430.6	-	-	-	-
Дүн	14	6,877,366.6	3	1,059,485.8	11	5,817,880.8	14	6,877,366.6	-	-	-	-

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл*(мянган төгрөг)*

Байгууллагын нэр	Бүгд	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	Түүвэрт	Нийт зөрчил		Үүнээс									
							Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Цогт сумын Засаг дарга	1	-	1	-	-	-	4	194,407.6	1	3,157.7	1		3	191,249.9				
Цогт сумын Засаг даргын Тамгын газар	1	1	-	-	-	-	4	6,334.9					3	6,334.9				

Цогт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1	-	-	-	-	1	1	6,438.2			1	6,438.2	-	-	-	-	-	-
Цогт сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	-	-	-	-	1	1	7,100.5			1	7,100.5	-	-	-	-	-	-
Цогт сумын Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан	1	-	-	-	-	1		-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Цогт сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	-	-	-	-	1	1	17,566.5	1	17,566.5	-	-	-	-	-	-	-	-
Дүн	6	1	1	-	-	4	11	231,847.7	2	20,724.2	3	13,538.7	6	197,584.8	-	-	-	-

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөг)

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цогт сумын Засаг даргын Тамгын газар	1	-	-	-	-	-	1	-
	1	180,496.30	-	-	-	-	1	180,496.30
	2	11,974.30			2	11,974.30		
Дүн	4	192,470.6	0	0	2	11,974.3	2	180,496.30

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТТЗ	1	1	-	-	-	1	-	-
2	ТШЗ	1	1	-	-	1	-	-	-
3	ОНТС	4	-	4	-	-	-	-	-
	НИЙТ	6	2	4	-	1	1	-	-